

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд “18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг “0.6” гэж, Шимтгэлийн дүн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж,” гэж заасныг энэ хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хэвээр мөрдөнө.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн дотор тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан даатгуулагчийн 2027 он хүртэл хуримтлуулсан тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн мөнгөн хуримтлалын гарааны үлдэгдэл болгон хуваарилж бүртгэх ажлыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ. Энэ хугацаанд хүсэлт гаргаагүй даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн даатгалын санд буцаан төвлөрүүлнэ.

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ